



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
АРВАНТАВДУГААР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 08

Чингис хот

[Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг
хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай]

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арвантавдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөтөлбөр, төлөвлөгөөг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв санхүүг жил бүр аймаг, сумын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, аялал жуулчлал, хөдөөгийн хөгжлийн хороо /Ч.Батгэрэл/-нд даалгасугай.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 08 дугаар
тогтоолын нэгдүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ

ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР (2023-2032 ОН)

Дунд хугацааны бодлогын баримт бичиг

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасан ба Хог хаягдлын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Ногоон хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хэнтий аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хог хаягдлын менежментийг сайжруулж хог хаягдлыг бууруулах, хүн амын амьдрах тав тухтай эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх зорилтуудыг үндэслэн боловсруулав.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

2.1 Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Алсын хараа: Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны чанар, уур амьсгалын өөрчлөлтөнд нөлөөлж байгаа хог хаягдлын сөрөг нөлөөг байж болох хамгийн бага түвшинд байлгах хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоог бий болгоно.

Эрхэм зорилго: Төр, хувийн хэвшил, олон нийтийн гурван талт хамтын ажиллагаанд тулгуурлан, хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй, хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн жишиг аймаг болно.

Стратегийн зорилго, зорилтууд: Хэнтий аймагт хог хаягдлын тогтвортой менежментийг нэвтрүүлэх хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө нь хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих замаар хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хог хаягдлаас учруулах сөрөг үр дагаврыг бууруулах үндсэн зорилготой.

Энэхүү үндсэн зорилгын хүрээнд дараах стратегийн зорилго, зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1 Хог хаягдлын тогтвортой менежментийг нэвтрүүлэх зохицуулалтын хүрээ, институцийг бүрдүүлнэ.

2.1.1.1 Хатуу хог хаягдлын менежментийн харилцааг зохицуулах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангулж, хог хаягдлыг ангилах ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг эдийн засгийн хөшүүргээр дэмжих зохицуулалтыг бий болгох.

2.1.1.2 Хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоог бий болгоход шаардлагатай бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах

2.1.1.3 Сум бүр хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

2.1.1.4 Хог хаягдлын менежментийн салбарт шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах.

2.1.1.5 Үр дүнтэй хяналт шинжилгээ, тайлагналын механизмыг бүрдүүлэх

2.1.2 Бүх нийтэд хог хаягдлын талаарх боловсрол олгох сургалт нөлөөллийн ажлыг эрчимтэй явуулж, эх үүсвэрт нь ангилах дадал зуршлыг хэвшүүлснээр хог хаягдлын тогтвортой менежментийг нэвтрүүлэх суурь үндсийг бий болгоно.

2.1.2.1 Хог хаягдлын албан бус боловсролыг хүүхдийн сургуулийн өмнөх наснаас эхлэн үр дүнтэй, оновчтой арга хэлбэрээр олгох сургалтын

2.1.2.2 Баг, хэсэг, аж ахуйн нэгж, байгууллага бүрт хурч ажиллах хог хаягдлын албан бус боловсрол олгох сургагч багш нарыг бэлтгэх.

2.1.2.3 Хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийг татан оролцуулах.

2.1.2.4 Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж, үйл ажиллагааг нь бүх талаар дэмжих.

2.1.2.5 Аж ахуйн нэгж, байгууллага бүр байгаль орчны хариуцлагыг хэрэгжүүлж, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх.

2.1.3 Хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжих замаар байгальд булж устгах хог хаягдлын хэмжээг 45 хувиар бууруулна.

2.1.3.1 Хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилах үйл ажиллагааг хэвшүүлж, дахивар нөөцийн үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэх.

2.1.3.2 Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах үйлчилгээнд хувийн хэвшлийг түлхүү оролцуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

2.1.3.3 Хог хаягдлын менежментийг сайжруулахад шаардлагатай дэд бүтцийг байгуулж, орон нутгийн онцлогт тохирсон дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

2.1.3.4 Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар үүсэх хог хаягдлын хэмжээгээ бууруулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бүх талаар дэмжих.

2.1.3.5 Хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах

2.1.4 Аюултай хог хаягдлын цогц менежментийг бий болгоно.

2.1.4.1 Аюултай хог хаягдлын шинж чанар, хор хөнөөл, түүнтэй хэрхэн аюулгүй харьцах, зөв устгах талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх.

2.1.4.2 Аюултай хог хаягдлын тооллого, бүртгэлийн системийг сайжруулах

2.1.4.3 Аюултай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, устгах чадавхийг бий болгох.

2.1.4.4 Аюултай хог хаягдалд тавих хяналтыг сайжруулж, аюултай хог хаягдлаас үүдэлтэй болзошгүй сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоо бүрдүүлэх

2.1.5 Хог хаягдлын тогтвортой менежментийн санхүүжилтийн орчинг бүрдүүлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах.

2.1.5.1 Хог хаягдлын төлбөр хураамжийг "Бохирдуулагч нь төлөх", "Үүсгэгч нь хариуцах" зарчмыг баримталж, хог хаягдлын менежментийн хэрэгжилт, үйл ажиллагаанд шаардагдах зардлыг нөхөн олж байхаар санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох.

2.1.5.2 ХХМ-ийн салбарт төсвөөс зарцуулж буй төсвийн хөрөнгийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлын менежментдээ зарцуулж байгаа зардлын үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулалтын зарчим нэвтрүүлэх

2.1.5.3 Хог хаягдлын менежментийн үйл ажиллагаанд санхүүжилтийн олон хэлбэрийг үр дүнтэй ашиглах.

2.1.5.4 ХХМ-ийн үйлчилгээний чанар, бүтээмж, үр ашигийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөрөнгө оруулалтын төслүүд боловсруулж хэрэгжүүлэх талаар хувийн хэвшилтэй түншлэлийн хүрээнд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх.

2.1.5.5 Хог хаягдлыг дахин боловсруулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг ногоон худалдан авалтаар дэмжих.

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

2.2.1 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулахыг эрмэлзэх;

2.2.2 Хог хаягдлын ангилан ялгалт, дахин ашиглалт, дахин боловсруулалтыг хөхүүлэн дэмжих;

2.2.3 Хог хаягдлыг байгаль орчинд хал багатай арга технологиор зайлцуулж устгах;

2.2.4 Үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлын менежментийг тухайн үүсгэгчээр нь хариуцуулах, бохирдуулагч нь төлбөр төлөх;

2.2.5 Иргэд, хувийн хэвшлийн оролцоог дэмжих, төр-хувийн хэвшил-олон нийтийн гурван талт түншлэлд тулгуурлах;

2.2.6 Гадаад орны хог хаягдлын менежментийн тэргүүн туршлагыг өөрийн онцлогт тохируулан бүтээлчээр нэвтрүүлэх;

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ҮР ДҮН

3.1 Хамрах хүрээ

Энэхүү хөтөлбөр, төлөвлөгөө нь Хэнтий аймгийн 18 сум, 5 тосгодын нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд, айл өрх, иргэдэд хамаарна.

3.2 Хөтөлбөрийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2.1 Нэгдүгээр үе шат (2023-2025 он):

Хог хаягдлыг бууруулахад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн орчин, институцийн бүтэц зохион байгуулалт, менежментийг сайжруулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх. Хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилж, эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл ажиллагааг эхлүүлж, дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой дахивар нөөцийн хэмжээг нийт хог хаягдлын **27%-д** хүргэнэ.

3.2.2 Хоёрдугаар үе шат (2026-2028 он):

Хог хаягдлын менежментийн дэд бүтэц, хүний нөөц, санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, байгаль орчны хариуцлагыг нэмэгдүүлэх, урамшууллын системийг нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг **40%-д** хүргэнэ.

3.2.3 Гуравдугаар үе шат (2029-2032 он):

Хог хаягдаас үүдэлтэй орчны доройтлыг нөхөн сэргээх, хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах хэмжээг нэмэгдүүлэх, дахин бүтээгдэхүүний чанарыг сайжруулах үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх замаар эрүүл цэвэр орчинг бүрдүүлж, үр дүнтэй, урт хугацааны хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоог бүрдүүлэн, дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээг **45%-д** хүргэнэ.

ДӨРӨВ. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- Улсын болон орон нутгийн төсөв
- Орон нутгийн хөгжлийн сан
- Олон улсын төсөл, хөтөлбөр
- Олон улсын байгууллагын зээл, тусlamж
- Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- Хог хаягдлын хураамж

- Тохижилт үйлчилгээний ОНӨҮГ-ын хөрөнгө оруулалт
- Хуулиар зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр

ТАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1 Хөтөлбөр, төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийг сумдын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Эрүүл мэндийн газар, Авто тээврийн төв, Орон нутгийн өмчит тохижилт үйлчилгээний газрууд болон бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүд хангаж, хамтран хариуцаж ажиллана.

5.2 Аймгийн Засаг даргын 2022 оны А/126 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн ахлагч (аймгийн Засаг даргын орлогч), нарийн бичгийн дарга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга) нь хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг хангах, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, ажлын явц, хэрэгжилтийг нэгтгэн үр дүнг тооцох, тайлагнах ажлыг хариуцна.

5.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч сумдын Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллагууд нь хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах төсвийг жил бүр аймаг, сумын жилийн хөгжлийн төлөвлөгөө, төсөвт тусгуулж хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газар хяналт тавьж, хэрэгжилтийг зорилт, үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн дагуу жил бүр үнэлж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

6.2 Холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу хариуцлага ногдуулна.

-----оо-----

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
15 дугаар хуралдааны 08 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2023-2032 ОН)

| Үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин (2021 он) | Зорилтот түвшин | | | Санхүүгийн эх үүсвэр | Хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан | |
|---|---|---|------------------------------|---------------------------------|--------------------------|---------------------------|-------------------------|--|-------------------------|
| | | | | I үе шат (2023-2025) | II үе шат (2025-2028) | III үе шат (2029-2032) | | Үндсэн хэрэгжүүлэгч | Хамтран хэрэгжүүлэгч |
| 1. Хог хаягдлын тогтвортой менежментийг нэвтрүүлэх зохицуулалтын хүрээ, институцийг бүрдүүлнэ. | | | | | | | | | |
| | Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, эрх зүйн орчныг сайжруулах. | Шинээр гаргах, сайжруулах эрх зүйн баримт бичгийн тоо | 1 | 2023 онд сайжруулах 1, шинээр 4 | | | - | БОАЖГ | АИТХ, АЗДТГ |
| 1.1. Хатуу хог хаягдлын менежментийн харилцааг зөхицуулах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангулж, хог хаягдлыг эх үүсвэрт нь бууруулах, ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг эдийн засгийн хөшүүргээр дэмжих зохицуулалтыг бий болгох. | Хог хаягдлын талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, менежментийг сайжруулах, хэрэгжилтэнд хяналт тавьж санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Хог хаягдлын олон нийтийн зөвлөл байгуулсан ажиллуулах. | Зөвлөлийн ажиллах журам батлагдаж, сум болгоны төлөөлөл оролцсон зөвлөл байгуулсан байна | - | 2023 онд 1 | | | - | АЗДТГ | БОАЖГ |
| | Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулахад олон нийтийн оролцоог хангаж, төр-хувийн хэвшил-олон нийтийн үр дүнтэй түншлэл тогтоох. | Мэргэжлийн Төрийн бус байгууллагы болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагууд тай хамтран ажиллах түншлэл байгуулсан байна. | - | 2023 онд 2 | | | орон нутгийн төсөв | АЗД | АЗДТГ |
| | Олон улсын сайн туршлагыг судлан нэвтрүүлэх. | Нэвтрүүлсэн сайн туршлага | - | 2023 онд 1, 2024 онд 1 | | | орон нутгийн төсөв | АЗД | БОАЖГ |

| | | | | | | | | | |
|--|--|--|---|---------------------------------------|--|--|--------------------|-------------------------|------------------------------------|
| | Бүтэц, зохион байгуулалтанд үнэлгээ хийж, хог хаягдлын менежментэд оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгон журамлаж өгөх. | Хууль, тогтоомжийн Хэрэгжилт сайжирсан байна. | - | 2023 онд 1 | | | | АЗДТГ | Бүх шатны ЗД, СЗДТГ |
| 1.2. Хог хаягдлын тогтвортой менежментийн тогтолцоог бий болгоход шаардлагатай бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах. | Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хог хаягдлын менежмент хариуцсан орон тоо бий болгож хариуцсан ажилтан томилж ажиллуулна. | Тусдаа орон тоо бий болгох, эсвэл ХХМ хариуцсан мэргэжилтэн томилсон байна. | - | 1 | | | орон нутгийн төсөв | БОАЖГ | АЗДТГ |
| | Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулах журмын дагуу сумдын баг бүрт хог хаягдлын олон нийтийн байцаагчийн ажлын байр бий болгон ажиллуулах | Олон нийтийн байцаагчийн орон тоо бий болгон, сонгон шалгаруулж ажиллуулсан байна. | - | 2023 онд 18, 2024 онд 22, 2025 онд 20 | | | орон нутгийн төсөв | Сумын Засаг дарга /СЗД/ | СЗДТГ |
| | Эдийн засгийн салбаруудаас үүсэх хог хаягдлын менежментийг тухайн салбарыг хариуцсан орон нутгийн нэгж нь хэрэгжүүлдэг тогтолцоог бүрдүүлэх. Тухайлбал, Барилга, зам тээвэр, эрүүл мэнд, боловсрол, уул уурхай, хүнс, хөдөө аж ахуй, газар тариалан г.м. | Тогтолцоо бүрдсэн байна. | - | 2023 онд | | | | АЗДТГ, БОАЖГ | ГХБХБГ, БШУГ, АТТ, ЭМГ, ХХААГ, МЭГ |
| 1.3. Сум бүр хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх. | Сумын хог хаягдлын урсالыг тогтоож, хог хаягдлыг устгах менежментийг тодорхойлох. | Дахин боловсруулах боломжтой хог хаягдлын эзлэх хувийг тооцсон байна. | - | 2023 онд | | | | СЗДТГ | СЗДТГ, ТҮГ |
| | Бүх төрлийн хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааны зардлыг тооцоолох, зардал үр ашгийн дүн шинжилгээ хийх | Хог хаягдлын үйлчилгээний хураамж нь үүсч байгаа хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд | - | 2023 онд | | | орон нутгийн төсөв | СЗДТГ | СЗДТГ, ТҮГ |

| | | | | | | | | | |
|--|---|--|-------|----------------------|----------------------|-------------|---|-------------|--|
| | | хүрэлцэхүйц байх, /%-иар тооцно/ | | | | | | | |
| 1.4. Хог хаягдлын менежментийн салбарт шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах. | Сумын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, үүрэг хариуцлагыг тодорхойлж, хэрэгжилтийг бүрэн хангуулах. | Ажлын үр дүн, тухайн сумын дахин боловсруулсан хог хаягдлын нийт хог хаягдалд эзлэх хувь хэмжээгээр /%-иар/ тодорхойлгдоно | 0.12% | 2023 онд | | | орон нутгийн төсөв | СЗДТГ | СЗДТГ |
| | Нүхэн жорлон ашиглагч ААНБ-ын болон гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлонг MNS 5924:2015 стандартад нийцүүлэн сайжруулах ажлыг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулна. | Нүхэн жорлонгоо сайжруулсан айл өрх, ААНБ-ын эзлэх хувиар тооцно. | - | 5% | 10% | 20% | орон нутгийн төсөв, хувийн хэвшил, өрхийн орлогын эх үүсвэр | СЗДТГ | СЗДТГ, БЗД, ААНБ-ын удирдлага, айл өрх |
| | Удирдлага, зохион байгуулалтын механизмыг хэрэгжүүлэх удирдамж боловсруулж, мөрдөх. | Удирдамж боловсруулж, мөрдөж ажилласан байна | - | 2023 онд | | | орон нутгийн төсөв | СЗДТГ | СЗДТГ |
| | Хог хаягдлын менежмент, дахин боловсруулах үйлдвэрлэлийн технологи, химийн инженерчлэл, цахилгаан, тоног төхөөрөмжийн инженер, засварчин, гагнуурчин зэрэг нарийн мэргэжлүүдээр боловсон хүчин бэлтгэх. | Мэргэжилтэй боловсон хүчиний тоо | - | 2025 онд 10 | 2028 онд 20 | 2032 онд 30 | улс, орон нутгийн төсөв | БШУГ, ПТК | ААНБ-ын удирдлагууд |
| | Хог хаягдлын менежментийн салбарт ажиллаж байгаа ажилтнуудыг давтан сургах, туршлага судлуулах, дадлагажуулах, мэдлэг мэдээллээр тогтмол хангаж, чадавхижуулах, | Сургалтанд хамрагдсан ажилтнуудын тоо | - | жил бүрт 30, нийт 90 | жил бүрт 30, нийт 90 | | орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө | БШУГ, СЗДТГ | БОАЖГ, ТҮГ, ААНБ-ын удирдлагууд |

| | | | | | | | | |
|---|--|--|----|--|------------------|------------------|---|----------------------------------|
| | ур чадварыг нэмэгдүүлэх. | | | | | | | |
| | Хог хаягдлын салбарт мөрдөгдж буй хууль тогтоомж, стандарт шаардлагыг чанд мөрдүүлж, ажиллагдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж, нийгмийн асуудлыг нь шат дараатай шийдвэрлэх. | Ажлын байранд гарч болзошгүй ХАБЭА-тай холбогдох осол гэмтлийн тоо | - | 0 | 0 | 0 | орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө | СЗДТГ ТҮГ, ААНБ-ын удирдлагууд |
| 1.5. Хог хаягдлын менежментийн үр дүнтэй хяналт шинжилгээ, тайлагнальн механизмыг бүрдүүлэх | Хог хаягдлын мэдээллийг цуглуулах, бүртгэх, хяналт тавих, тайлагнах механизмыг сайжруулна. | Мэдээ тайлангийн программ хийх | - | 2023 онд 1 | | | Орон нутгийн төсөв | БОАЖГ Статистикийн хэлтэс |
| | Үүсч буй хог хаягдлын нэр төрөл, шинж чанарыг болон хэмжээ, бүтцийг өвөл, зуны улирлаар тогтоох, хог хаягдал үүсгэгчдийн зан төлвийг тодорхойлох судалгааг гурван жил тутамд тогтмол хийж, үр дүнг менежментийг сайжруулахад ашиглаж хэвших. | Судалгааны үр дүн | - | 2023 онд 1 | 2026 онд 1 | 2029 онд 1 | Орон нутгийн төсөв | СЗДТГ БОАЖГ, Статистикийн хэлтэс |
| | Аймаг, сумдын хог хаягдлын мэдээллийн сангийн үйл ажиллагааг идэвхижүүлэх, мэдээллийн шуурхай, үнэн зөв, бодит байдлыг дээшлүүлэх, мэдээллийн сангийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах. | Аймгийн нэгдсэн болон сумдын дэд сан байна. | 18 | 2023 онд үүсгэх, Аймгийн нэгдсэн 1, сумын дэд сан 18 | тогтмол ажиллана | тогтмол ажиллана | Орон нутгийн төсөв | Статистикийн хэлтэс БОАЖГ, СЗДТГ |

2. Бүх нийтэд хог хаягдлын талаарх боловсрол олгох сургалт нөлөөллийн ажлыг эрчимтэй явуулж, эх үүсвэрт нь ангилах дадал зуршлыг хэвшүүлснээр хог хаягдлын тогтвортой менежментийг нэвтрүүлэх суурь үндсийг бий болгоно.

| | | | | | | | | | |
|---|---|--|----|--|---------------------------|---------------------------|---|-------|---|
| | Хог хаягдлын албан бус сургалт явуулах сургалтын хөтөлбөрийг суурь судалгаанд үндэслэж, нийгмийн бүлэг, иргэдийн насны онцлог зэрэгт тохируулан боловсруулж, явуулах | Хог хаягдлын албан бус боловсрол олгох сургалтанд хамрагдсан хүн амын эзлэх хувь | - | 2023 онд 10%, 2024 онд 20%, 2025 онд 30% | 70% | 100% | орон нутгийн төсөв | БШУГ | БОАЖГ, СЗДТГ, БЗД, ААНБ, ТББ |
| | Ерөнхий боловсролын сургуулиудын эко-клубыг чадавхижуулж, хүүхэд запууст болон олон нийтэд мэдээлэл түгээх, зөв дадал хэвшүүлэх ўйл ажиллагаа явуулахыг бүх талаар дэмжих. | Эко-клубээр дамжуулж хог хаягдлын боловсрол олгох сургалтанд хамрагдах сурагчдын эзлэх хувь хэмжээ | 10 | 50% | 70% | 100% | орон нутгийн төсөв | БШУГ | СЗДТГ, ЕБС-ийн захирал, ТББ |
| 2.1. Хог хаягдлын албан бус боловсролыг хүүхдийн сургуулийн өмнөх нааснаас эхлэн үр дүнтэй, оновчтой аgra хэлбэрээр олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх. | Хог хаягдлын талаарх уламжлалт мэдлэг ойлголт, хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилах, дахин ашиглах, дахин боловсруулахын ач холбогдол, хог хаягдлын хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчны чанарт үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээг ашиглан ухуулан таниулах, сурталчлах ажлыг тогтмол явуулах. | Олон нийтэд зориулсан ухуулан таниулах, сурталчлан дэлгэрүүлэх нөлөөллийн ажлын тоо /1 жилд/ | - | Сар болгон 1, нэг жилд 12 | Сар болгон 1, нэг жилд 12 | Сар болгон 1, нэг жилд 12 | орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө | ЭМГ | БШУГ, СЗДТГ, БОАЖГ, Хэвлэл мэдээллийн алба, ААНБ, ТББ |
| | Олон нийтийг хамарсан "Хоггүй Хэнтийчүүд" аян, сумдаас дахивар нөөц цуглуулах аян, айл өрхийн болон ААНБ-ын сайн туршлагыг сурталчлах, сар, улирлын, хаврын болон эх дэлхийгээгээ цэвэрлэх өдрийн нийтийн их цэвэрлэгээ зэрэг нөлөөллийн ажлуудыг өргөн зохион байгуулах. | Жилд зохион байгуулах нөлөөллийн ажлын тоо | 4 | Сар болгон 1, нэг жилд 12 | Сар болгон 1, нэг жилд 12 | Сар болгон 1, нэг жилд 12 | орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө | СЗДТГ | БОАЖГ, БШУГ, ААНБ, айл өрх, иргэд |

| | | | | | | | | | |
|---|---|--|---|---------------------------------------|-----|------|-------------------------|-----------------|--|
| | Аймгийн төв Хэрлэн сумын иргэдэд чиглэсэн сургалт явуулах сургагч багш бэлтгэж сертификатжуулах. | Бэлтгэсэн сургагч багшийн тоо | - | 2023 онд 32 сургагч багш | | | орон нутгийн төсөв | Хэрлэн сум ЗДТГ | БШУГ, БОАЖГ, БЗД, ТББ |
| 2.2. Иргэн, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага бүрт хүрч ажиллах хог хаягдлын албан бус боловсрол олгох сургагч багш нарыг бэлтгэж, ур чадварыг байнга дээшлүүлэх. | Бусад сумдын иргэдэд сургалт явуулах тус бүр 2 сургагч багш бэлтгэх | Бэлтгэсэн сургагч багшийн тоо | - | 2023 онд 34 сургагч багш | | | орон нутгийн төсөв | СЗДТГ | БШУГ, БОАЖГ, БЗД, ТББ |
| | Сургуулийн өмнөх наасны болон ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сургачдад боловсрол олгох сургагч багш нар бэлтгэх. | Бэлтгэсэн сургагч багшийн тоо | - | 2023 онд 108 | | | орон нутгийн төсөв | БШУГ | ЕБС, Цэцэрлэгийн удирдлага |
| | Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын сургагч багш | Бэлтгэсэн сургагч багшийн тоо | - | 2023 онд 102 | | | орон нутгийн төсөв | СЗДТГ | БШУГ, Агентлаг, байгууллагын удирдлага |
| | "Үүсгэгч нь хариуцах" зарчмыг баримтлан үйлдвэрлэгч болон импортлогч нь өөрсдийн үйлдвэрлэсэн, импортлосон бараа бүтээгдэхүүнээс гарах хог хаягдлаа бүрэн хариуцах үйлдвэрлэгч, импортлогчдын тоо | Үйлдвэрлэсэн, импортлосон бараа бүтээгдэхүүнээс гарах хог хаягдлаа бүрэн хариуцах үйлдвэрлэгч, импортлогчдын тоо | - | 2024 онд 5, 2025 онд 10 | | | Хувийн хэвшлийн хөрөнгө | БОАЖГ | СЗДТГ, ХХААГ, ААНБ-ын удирдлага |
| 2.3. Хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийг татан оролцуулах, хамтран ажиллах. | Аж ахуйн нэгжийн сайн туршилагыг олон нийтэд сурталчлах | Хамтран зохион байгуулах нэлөөллийн ажлын тоо | - | 2023 онд 6, 2024 онд 6, 2025 онд 6 | | | Хувийн хэвшлийн хөрөнгө | СЗДТГ | БОАЖГ, ААНБ-ын удирдлага |
| | Аж ахуйн нэгж байгууллагын удирдлагад өөрөө болон ажилтнуудаа хог хаягдлын талаархи сургалтад бүрэн хамруулан, зохих мэдлэгийг эзэмшүүлж, дадал зуршлыг хэвшүүлэх ажлыг үүрэгжүүлж, мөрдлөг болгох. | Хог хаягдлын тогтвортой менежментийг нэвтрүүлсэн байгууллага, сургалтанд хамрагдсан ажилтнуудын тоо, хувиар | - | 2023 оноос эхлүүлэх, эхний үе шат 50% | 70% | 100% | Хувийн хэвшлийн хөрөнгө | АЗДТГ | СЗДТГ, БОАЖГ, Агентлаг, байгууллага, ААНБ-ын удирдлага |

| | | | | | | | | | |
|--|--|--|---|---------------------------------------|-----|------|-------------------------|---------------------|--------------------------|
| | Баг бүрт хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж, үйл ажиллагааг нь бүх талаар дэмжих. | Иргэдийн бүлгийн тоо | - | 2023 онд 20 | | | Хувийн хэвшлийн хөрөнгө | СЗДТГ | БЗД |
| | Аймаг, сумын Засаг дарга нар болон тэдгээрийн Тамгын газар нь иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллах. | Үзүүлсэн дэмжлэгийн хэлбэр | - | 2023 онд 3, 2024 онд 4, 2025 онд 3 | | | орон нутгийн төсөв | СЗДТГ | АЗДТГ, СЗДТГ, БЗД |
| 2.4. Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж, үйл ажиллагааг нь бүх талаар дэмжих. | Аж ахуйн нэгж, байгууллага нь Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг чанд сахин биелүүлж ажиллах. | Гарсан, илэрсэн, арга хэмжээ тооцсон зөрчлийн тоо | - | 2023 оноос эхлэн тогтмол | 0 | 0 | Хувийн хэвшлийн хөрөнгө | ААНБ-ын удирдлага | СЗДТГ, БЗД |
| 2.5. Аж ахуйн нэгж, байгууллага бүр байгали орчны хариуцлагыг хэрэгжүүлж, хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлага тавьж ажиллах. | Үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага бүрт хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлага тавьж ажиллах. | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь /%-иар/ | - | 2023 оноос эхлүүлэх, эхний үе шат 50% | 70% | 100% | Хувийн хэвшлийн хөрөнгө | АЗДТГ, СЗДТГ, БОАЖГ | ААНБ-ын удирдлага |
| | Шинээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, сумын хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтнээр хянуулж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч ажиллах. | Шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь /%-иар/ | - | 2023 оноос эхлэн хэвшүүлэх | 70% | 100% | Хувийн хэвшлийн хөрөнгө | СЗДТГ | БОАЖГ, ААНБ-ын удирдлага |

| | | | | | | | | | |
|--|---|--|---|---------------------------------------|-----|------|-------------------------|--|--------------|
| | Үүсэх энгийн хог хаягдлаа эх үүсвэрт нь ангилах ажлыг хэвшүүлж, ангилалын дагуу түр хадгалах шаардлага хангасан хогийн савтай байх шаардлагыг хангаж ажиллах. | Аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь /%-иар/ | - | 2023 оноос эхлүүлэх, эхний үе шат 50% | 70% | 100% | Хувийн хэвшлийн хөрөнгө | Агентлаг байгуулла гууд, ААНБ-ын удирдлага | СЗДТГ, БОАЖГ |
| | Дэвшилтэт арга төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг бууруулах үүрэг хүлээж ажиллах. | арга тоног Үйлдвэрийн газрын эзлэх хувь /%-иар/ | - | 2023 оноос эхлүүлэх, эхний үе шат 50% | 70% | 100% | Хувийн хэвшлийн хөрөнгө | ААНБ-ын удирдлага | СЗДТГ, БОАЖГ |

3. Хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг дэмжих замаар байгальд булж устгах хог хаягдлын хэмжээг бууруулна.

| | | | | | | | | | | |
|--|---|---|-------|--|---------------------|---------------------|--------------------|---------------|-----------|-----------------------------|
| 3.1. Хог хаягдлыг эх үүсвэрт нь ангилах үйл ажиллагааг хэвшүүлж, дахивар нөөцийн үр дүнтэй удирдлагыг хэрэгжүүлэх. | Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх | Дахин ашигласан, дахин боловсруулсан дахивар нөөцийн нийт хог хаягдалд эзлэх хэмжээ, хувиар | 0.12% | 27% | 40% | 45% | орон нутгийн төсөв | СЗДТГ, БОАЖГ | ТҮГ, ААНБ | |
| | Сумдын дахивар нөөц хүлээн авах цэгийг аймгийн төвийн дахивар нөөцийн удирдлагын төвтэй болон дахин боловсруулах үйлдвэрүүдтэй шууд холбосон тээвэр, ложистикийн тогтолцоо бий болгон, хөгжүүлэх. | Тээвэр, ложистикийн тогтолцоо бүрдсэн байна. | - | дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн дахивар нөөцийн хэмжээгээр тодорхойлогдоно, 2032 онд нийт хог хаягдлын 45%-д хүргэнэ. | | | | Хувийн хэвшил | АТТ | БОАЖГ, СЗДТГ, Хувийн хэвшил |
| | Дахивар нөөц хүлээн авах, эдийн засгийн эргэлтэнд оруулах үйл ажиллагааг хувийн хэвшилд тулгуурлан | Олгосон эдийн засгийн урамшууллын хэмжээ, төгрөгөөр | - | 2023 онд журам батлагдсан байна, журмаар | журмаар тодорхойлно | журмаар тодорхойлно | орон нутгийн төсөв | СЗДТГ | СИТХ | |

| | | | | | | | | | |
|--|--|--|-------|--|-----|------|-------------------------|--------------|--|
| | явуулж, урамшууллаар дэмжих. | | | тодорхойлог дох | | | | | |
| 3.2. Хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах үйлчилгээнд хувийн хэвшлийг түлхүү оролцуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх. | Аймгийн төв, сумдын алслагдсан гэр хороолол, зуслан, малчин айл өрхийг ХХМ-ийн үйлчилгээнд бүрэн хамруулж, хог хаягдал цуглуулах үйл ажиллагааг хувийн хэвшилд тулгуурлан тогтмол хуваарыт оруулах | Байгальд халгүй аргаар устгах хог хаягдлын эзлэх хувь | 99.88 | 73 | 60 | 55 | орон нутгийн төсөв | СЗДТГ | Тээвэрлэгч байгууллагын удирдлага |
| | Ногоон бүс, зуслан, голын эрэг, сав газар хог хаягдлыг түр хадгалах байгууламж барих, байршуулах | Түр хадгалах цэг, байгууламжийн тоогоор | 3 | 6 | 8 | 8 | орон нутгийн төсөв | СЗДТГ | БОАЖГ, ТХГНЗ, Голуудын СГЗ |
| | Ногоон бүс, зуслан, голын эрэг, сав газрын дагуух хог хаягдлыг цээрлэх, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээг олон нийтийн хяналтад тулгуурлан сайжруулах | Ил задгай хууль бусаар хаягдах хог хаягдлын хэмжээ /%-иар/ | - | 0 | 0 | 0 | орон нутгийн төсөв | СЗДТГ | БОАЖГ, ТХГНЗ, Голуудын СГЗ, Иргэдийн бүлэг |
| | Ногоон бүс, голын эрэг, сав газрын бүсэд хяналт шалгалт, үнэлгээ, торгуулийн тогтолцоо нэвтрүүлэх | Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг тооцож хэвшсэн байна. /Илрүүлсэн зөрчил бүрт 100%/ | - | 70% | 90% | 100% | орон нутгийн төсөв | СЗДТГ | СЗДТГ, ХХОНБ, Иргэдийн бүлэг |
| 3.3. Хог хаягдлын менежментийг сайжруулахад шаардлагатай дэд бүтцийг байгуулж, орон нутгийн онцлогт тохирсон дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх. | Аймгийн төвд ангилсан дахивар нөөцийг цуглуулах, тээвэрлэх, хулээн авах, дамжуулах зохицуулалтыг хариуцах удирдлагын төв, сумдад дахивар нөөц хулээн авах цэг байгуулж, бүх талаар дэмжих ажиллах | Байгуулсан удирдлагын төв, дахивар нөөц хулээн авах тогтмол ажиллагаатай төв, цэгийн тоо | - | 2023 онд төв -1, цэг -5, 2024 онд цэг 17 | | | Улс, орон нутгийн төсөв | АЗДТГ, СЗДТГ | ТҮГ, БОАЖГ, Иргэдийн бүлэг, хувийн хэвшил |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|-------------------------------------|-----|------|---|-------|---|
| | <p>Хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх тээврийн хэрэгслийн парк шинчлэлтийг хийх төлөвлөгөөг боловсруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, ангилсан хог хаягдлыг ангилалын дагуу тусад нь тээвэрлэх чадавхи бий болгох.</p> | <p>Ангилалын дагуу тусад нь цуглуулж тээвэрлэсэн хог хаягдлын нийт хог хаягдапд эзлэх хувь</p> | - | 27% | 40% | 45% | Улс, орон нутгийн төсөв | СЗДТГ | АЗДТГ, БОАЖГ, Тээвэрлэгч байгууллагын удирдлага |
| | <p>Цахим, цахилгаан барааны хаягдал хүлээн авч түр хадгалах цэг байгуулах</p> | <p>Үүссэн болон цуглуулсан цахим, цахилгаан барааны хаягдлын хэмжээ, хувиар</p> | - | 50% | 70% | 100% | Хувийн хэвшил | СЗДТГ | Хувийн хэвшил, Иргэдийн бүлэг |
| | <p>Сумдад дахин ашиглах, дахин боловсруулах боломжгүй, шатах хог хаягдлыг байгальд халгүй технологиор шатааж устгах зориулалттай байгууламж барих</p> | <p>Байгуулах шатаах үйлдвэрийн тоо</p> | - | 2023 онд 1, 2024-2025 онд тус бүр 2 | 4 | 3 | ОНТ | СЗДТГ | Хувийн хэвшил |
| | <p>Аймгийн төвд шинэ техникик технологи, инноваци шингэсэн хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр барьж байгуулах.</p> | <p>байгуулах үйлдвэрийн тоо</p> | - | 1 | | | Улсын төсөв | АЗДТГ | БОАЖГ, СЗДТГ, Хувийн хэвшил |
| 3.4. Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд эзлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар үүсэх хог хаягдлын хэмжээгээз бууруулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг бүх талаар дэмжих. | <p>Хог хаягдлыг дахин боловсруулах болон сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татварын бодлогоор дэмжих.</p> | <p>Орон нутгаас тогтоодог татварын төрлүүдээр хөнгөлөлт үзүүлсэн иргэн, ААНБ-ын тоо</p> | - | 2024 оноос журамлаж хэрэгжүүлэх | | | орон нутгийн төсөв | АЗДТГ | ТХ, СЗДТГ, БОАЖГ |
| | <p>Хөнгөлөлттэй зээлд хамруулах, эдийн засгийн урамшуулалт олгох зэрэгээр үйл ажиллагааг нь дэмжин урамшуулах.</p> | <p>Орон нутгийн хөгжлийн сан болон бусад хөнгөлөлттэй зээлд түлхүү хамруулж, дэмжлэг үзүүлсэн</p> | - | 2024 оноос хэрэгжүүлэх | | | орон нутгийн хөгжлийн сан, бусад хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр | СЗДТГ | ХХҮГ, ХХААГ, БОАЖГ |

| | | | | | | | | | |
|---|--|---|---|------------------------|------------------|---|---|--------------|-----------------------------------|
| | | иргэн, ААНБ-ын тоо | | | | | | | |
| | Газрын асуудалд нь дэмжлэг үзүүлэх. | Шуурхай шийдвэрлэсэн өргөдөл, хүснэгтийн тоо | - | 2023 оноос хэрэгжүүлэх | | | | СЗДТГ | ГХБХБГ |
| | Аймаг, сумын эрх хэмжээний хүрээнд бусад шаардлагатай дэмжлэг үзүүлэх | Шийдвэрлэсэн өргөдөл, хүснэгтийн тоо, хамрагдсан арга хэмжээний тоо | - | 2023 оноос хэрэгжүүлэх | | | орон нутгийн төсөв | АЗДТГ | СЗДТГ, БОАЖГ |
| 3.5. Хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгээс хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. | Хэрлэн сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг шинэчлэх зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах. | Зураг төсөл, ТЭЗҮ батлагдсан байх | - | 2023 онд | | | Улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүгийн болон техникийн туслалцаа | Хэрлэн СЗДТГ | АЗДТГ |
| | Хэрлэн сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг 1-2 дугаар зэрэглэлийн ландфилл байгууламж болгон шинэчлэх. | Ландфилл байгууламж байгуулсан байх. | - | 2024 онд | | | | СЗДТГ | АЗДТГ |
| | Сумдын хог хаягдлын төвлөрсөн цэгийг дор хаяж 3 дугаар зэрэглэлийн ландфилл цэг болгон шинэчлэх. | Шинэчлэгдсэн төвлөрсөн цэгийн тоо | 2 | 2025 он хүртэл нийт 8 | 2028 он хүртэл 7 | | улс, орон нутгийн төсөв | СЗДТГ | СИТХ |
| | Хаагдсан, үйл ажиллагаа нь зогссон хог хаягдлын төвлөрсөн цэгүүдэд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах. | Нөхөн сэргээлт хийсэн цэгийн тоо | - | 9 | 7 | | улс, орон нутгийн төсөв | СЗДТГ | БОАЖГ |
| | Зөвшөөрөлгүй, хууль бус, үүсмэл хогийн цэг шинээр үүсгэхээс урьдчилан сэргийлэх, байгаль орчны хяналтыг олон нийтэд тулгуурлан сайжруулах. | Зөвшөөрөлгүй, хууль бус хогийн цэгийн тоо | - | 0 | 0 | 0 | орон нутгийн төсөв | СЗДТГ | БОАЖГ, ТҮГ, ХХОНБ, Иргэдийн бүлэг |

4. Аюултай хог хаягдлын цогц менежментийг бий болгоно.

| | | | | | | | | | |
|--|--|---|-----|-----------------------|-----------------------|-------------------------|-------------------------|------------------|---|
| | Аюултай хог хаягдлын талаар сургалтанд хамрагдсан хүн амын эзлэх хувь /нийт хүн амд эзлэх %-иар/ | 0 | 50% | 70% | 100% | улс, орон нутгийн төсөв | БОАЖГ | БШУГ, СЗДТГ, ТББ | |
| 4.1. Аюултай хог хаягдлын шинж чанар, хор хөнөөл, түүнтэй хэрхэн аюулгүй харыцах, зөв устах талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх. | Аюултай хог хаягдлыг зайлцуулах, устгах, үйл ажиллагааны хүрээнд төрөл бүрийн аюултай хог хаягдлын бүтэц, найрлага, онцлог шинж чанар болон тэдгээрийг устах тохиромжтой арга, аргачлалыг таниулах. | Сургалтын тоо | 0 | Улирал бүр 1, нийт 12 | Улирал бүр 1, нийт 12 | Улирал бүр 1, нийт 16 | улс, орон нутгийн төсөв | БОАЖГ | БШУГ, СЗДТГ, ТББ |
| | Цахим, цахилгаан барааны хаягдал, ашиглалтаас гарсан автомашин, аккумлятор, хуруу зайд, хэрэглэсэн эм, тарианы үлдэгдэл зэрэг айл өрхөөс гарах аюултай хог хаягдлын тухай мэдлэг олгох. | Аюултай хог хаягдлын талаар сургалтанд хамрагдсан хүн амын эзлэх хувь | 0 | 50% | 70% | 100% | улс, орон нутгийн төсөв | БШУГ, БОАЖГ, ТББ | |
| 4.2. Аюултай хог хаягдлын тооллого, бүртгэлийн системийг сайжруулах. | Аюултай хог хаягдал үүсгэгчдийн судалгааг сайжруулж, уул уурхай, хунд үйлдвэрлэл, зам, тээвэр, барилга, харилцаа холбоо, хөдөө аж ахуй, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрлэл, эрүүл мэндийн болон мал эмнэлгийн зэрэг эдийн засгийн салбаруудын аюултай хог хаягдал үүсгэгчдийг бүртгэлд бүрэн хамруулна. | Аюултай хог хаягдал үүсгэгчдийн тоо /хамруулах %-иар/ | 40 | 50% | 70% | 100% | улс, орон нутгийн төсөв | БОАЖГ | Статистикийн хэлтэс, СЗДТГ, ААНБ-ын удирдлага |

| | | | | | | | | | |
|--|---|---|-----|--|--------------------|--------------------|--------------------------------|-------------------|--------------------------------------|
| | Аюултай хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын судалгаатай байна. | Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо, устгах хог хаягдлын тэрлеөр | 10 | 2023 онд улсын хэмжээнд 14 тусгай зөвшөөрөл эзэмшигч | жил бүр шинэчилнэ. | жил бүр шинэчилнэ. | улс, орон нутгийн төсөв | БОАЖГ | Статистикийн хэлтэс, СЗДТГ, ХХОНБ |
| | Аюултай хог хаягдлын тооллогыг 5 жил тутамд хийж, аюултай хог хаягдлын үүсэх хэмжээ болон бутэц, найрлагыг тогтоох ажлыг гүйцэтгэж хэвшинэ. | Тооллогын тоо, үр дүн | 0 | 2023 онд 1 | 2028 онд 1 | 2032 онд 1 | улс, орон нутгийн төсөв | БОАЖГ | Статистикийн хэлтэс, СЗДТГ |
| 4.3. Аюултай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах болон устгах чадавхийг бий болгох. | Аюултай хог хаягдал үүсгэгчдэд аюултай хог хаягдлын тухай сургалт явуулж, тавих хяналтыг сайжруулах. | Сургалт, хяналтанд хамрагдах хувь /%-иар/ | 20% | 60% | 80% | 100% | Орон нутгийн төсөв | БОАЖГ | СЗДТГ, ХХОНБ, Иргэдийн бүлэг |
| | Үүссэн аюултай хог хаягдлыг зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | Тусгай зөвшөөрөл бүхий этгээдэд шилжүүлэх аюултай хог хаягдлын эзлэх хувь /%-иар/ | 20% | 60% | 80% | 100% | - | ААНБ-ын удирдлага | БОАЖГ, СЗДТГ, ХХОНБ |
| | Үүсгэгч нь хариуцах зарчмын хүрээнд үйлдвэрлэсэн, импортлосон бараа, үйлчилгээнээс нь үүссэн аюултай материал, аюултай хог хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогч нь буцаан татдаг тогтолцоо бүрдүүлэх. | Буцааж татсан аюултай хог хаягдлын нийт аюултай хаягдалд эзлэх хувь /%-иар/ | - | 10 | 20 | 40 | - | АЗДТГ | БОАЖГ, СЗДТГ, ТББ, ААНБ-ын удирдлага |
| | Хэрлэн суманд үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлыг булшлах ландфилл байгууламж байгуулна. | Үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлын ландфилл байгууламжийн тоо | - | 1 | | | улс, орон нутгийн төсөв | АЗДТГ | БОАЖГ, СЗДТГ |
| | Хэрлэн суманд аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж байгуулан аюултай хог | Түр хадгалах байгууламж байгуулагдаж | - | 1 | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалт | АЗДТГ | БОАЖГ, СЗДТГ |

| | | | | | | | | | |
|--|---|---|--------------------|-----|---------|---------|-------------------------|--------------|--------------------------------------|
| | хаягдлыг төвлөрүүлэн түр хадгалж, аюулгүй ажиллагааг нь хангаж ажиллана. | ашиглалтанд орсон байна | | | | | | | |
| 4.4. Аюултай хог хаягдалд тавих хяналтыг сайжруулж, аюултай хог хаягдлаас үүдэлтэй болзошгүй серег нелөөнөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоо бүрдүүлэх. | Аюултай хог хаягдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, аюултай хог хаягдал үүсгэгчдэд тавих хяналтыг сайжруулснаар хүний эрүүл мэнд, байгаль экологид үзүүлж болзошгүй серег нелөөллөөс урьдчилан сэргийлэх. | Болзошгүй серег нелөө | - | 0 | 0 | 0 | - | АЗДТГ, БОАЖГ | СЗДТГ, ХХОНБ, ТББ, ААНБ-ын удирдлага |
| | Олон нийтэд аюултай хог хаягдлын тухай мэдлэг ойлголтыг түгээнээр аюултай хог хаягдлын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг сайжруулах. | Болзошгүй хор хөнөөл | - | 0 | 0 | 0 | орон нутгийн төсөв | АЗДТГ, БОАЖГ | СЗДТГ, ХХОНБ, ТББ, ААНБ-ын удирдлага |
| | Онцгой байдлын газрын аюултай хог хаягдлаас үүссэн хор хөнөөлийг арилгах чадвар /%-иар/ бүрдүүлэх. | Үүссэн хор хөнөөлийг арилгах чадвар /%-иар/ | - | 80% | 90% | 100% | улс, орон нутгийн төсөв | ОБГ | БОАЖГ, ААНБ-ын удирдлага |
| 5. Хог хаягдлын тогтвортой менежментийн санхүүжилтийн орчинг бүрдүүлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангана. | | | | | | | | | |
| 5.1. Хог хаягдлын төлбөр хураамжийг "Бохирдуулагч нь төлөх", "Үүсгэгч нь хариуцах" зарчмыг | Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тутамд тогтоох | 3 жил шинэчлэн | Шинэчилсэн хураамж | 1 | 2023 он | 2026 он | 2029 он | - | СЗДТГ СИТХ |

| | | | | | | | | | | |
|---|---------|--|---|---|--|------------------|---------------------------|---|-------|---|
| баримталж, хаягдлын менежментийн хэрэгжилт, ажиллагаанд шаардагдах зардлыг нөхөн олж байхаар санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгох. | хог үйл | Аялал жуулчлалын гол бүс нутагт хамаарах сумдад аялагч-жуулчдаас хог хаягдлын үйлчилгээний хураамж авах эрх зүйн орчныг бүрдүүлж, хураамжийн орлогыг зөвхөн аялал жуулчлалаас үүсэх хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд зарцуулж, хэвших. | Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас аялагч-жуулчдаас авах энгийн хог хаягдлын хураамжийн хэмжээг тогтоож, авч эхэлсэн байх | 1 | Аялал жуулчлалын бүс нутагт хамаарах сумд хэрэгжүүлнэ | | | - | СЗДТГ | СИТХ |
| | | Орон нутгийн өмчит тохижилт үйлчилгээний компанийг хувьчилж, хувийн хэвшилд шилжүүлэх. | Хувьд шилжүүлсэн байна | - | - | - | 2029 онд хувьчилсан байна | - | СЗДТГ | СИТХ |
| | | Хог хаягдлын үйлчилгээний хураамж, аюултай хог хаягдал болон барилгын хог хаягдлын үйлчилгээний хэлс, торгуулийн орлого болон гадаад, дотоод эх үүсвэрийн тусламж, хандивын орлогоос бүрдсэн сан байгуулж, шаардлагатай үйл ажиллагааг санхүүжүүлэх. | Санхүүжүүлэлтийн тогтвортой эх үүсвэрийг бий болгосон байна. | - | 2024 онд сан байгуулна. | тогтмол ажиллана | тогтмол ажиллана | - | СЗДТГ | АЗДТГ, хувийн хэвшил, ТББ |
| 5.2. Хог хаягдлын менежментийн салбарт зарцуулж буй төсвийн хөрөнгийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлын менежментдээ зарцуулж байгаа зардлын үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, | | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдаа эх үүсвэрт нь ангилан, дахин ашиглах, дахин боловсруулах боломжтой дахивар нөөцийг бэлтгэн эдийн засгийн эргэлтэнд оруулснаар, орлогоо нэмэгдүүлэх боломжтой болох. | Эдийн засгийн эргэлтэнд оруулснаар олох нэмэлт орлогын эх үүсвэр | - | 2023 оноос хэрэгжүүлнэ. Бэлтгэж нийлүүлсэн дахивар нөөцийн нэр төрөл, тоо хэмжээгээр тодорхойлгдоно. | | | - | СЗДТГ | Айл өрх, агентлаг байгууллагын удирдлага, Иргэдийн бүлэг, хувийн хэвшил |

| | | | | | | | | | |
|---|--|---|---------------------------------|---------------------------------------|------------------------|------------------------|---|--------------|--|
| үр ашигтай зарцуулалтын зарчим нэвтрүүлэх | ХХМ-ийн салбарт төсвөөс зарцуулж буй төсвийн хөрөнгийн болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлын менежментдээ зарцуулж байгаа зардлын үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, үр ашигтай зарцуулалтын зарчим нэвтрүүлэх | Хог хаягдлын үйлчилгээний хураамж нь үүсч байгаа хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд хүрэлцэхүйц байх, /%-иар тооцно/ | - | 2023 онд тарифыг шинэчилнэ. | 100% | 100% | - | СЗД | СЗДТГ, Тээвэрлэх, устгах үйл ажиллагаа эрхлэгч ААНБ-ын удирдлага |
| | Хог хаягдлыг "үүсгэгч нь хариуцах, бохирдуулагч нь төлөх" зарчмын хүрээнд хяналтыг сайжруулах. Үүнд, аюултай хог хаягдал, барилгын хог хаягдал, овор хэмжээ ихтэй хаягдалд тавих хяналтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хууль бус үйлдэлд хариуцлага тооцох. | Хариуцлага, түүнд тавих хяналтыг сайжруулснаар орлого төвлөрүүлэлт нэмэгдэнэ. Орлогын нэмэгдсэн %-иар тооцох | - | Хяналтыг 2023 оноос эхлэн сайжруулна. | Тогтмол хяналт тавина. | Тогтмол хяналт тавина. | орон нутгийн төсөв | АЗДТГ, БОАЖГ | СЗДТГ, БЗД, ХХОНБ, Иргэдийн бүлэг, ТББ |
| 5.3. Хог хаягдлын менежментийн үйл ажиллагаанд санхүүжилтийн олон хэлбэрийг үр дүнтэй нэвтрүүлэх. | Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бүрдүүлэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээс гадна, олон улсын байгууллагын эх үүсвэр, альтернатив эх үүсвэр зэрэг санхүүжилтийн олон хэлбэрийг ашиглах. | Хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн тоо | Одоо хэрэгжиж буй төслийн тоо 1 | Жил тус бүр 1 төсөл | 1 | | Олон улсын байгууллага, санхүүгийн зах зээл | АЗДТГ, БОАЖГ | СЗДТГ, Агентлаг байгууллага, хувийн хэвшил, ТББ |
| | Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, булж устгах зардлын нэгж тарифыг 3 жил тутамд шинэчлэх тогтоох. | Шинэчлэн тогтоох хураамж, тариф | 3 | 2023 онд | 2026 онд | 2029 онд | - | СЗДТГ | СИТХ, БОАЖГ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---------------------------|--------------|--|
| | Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагуудтай холбоо тогтоож, ногоон хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн зорилтот нийцсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, байгаль орчныг хамгаалах зорилгоор дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллах. | Хамтарч хэрэгжүүлэх төслийн тоо | - | 1 | 1 | 1 | Олон улсын байгууллага | АЗДТГ | БОАЖГ, СЗДТГ, ААНБ-ын удирдлага |
| 5.4. Хог хаягдлын үйлчилгээний чанар, бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, нэмүү өргтөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөрөнгө оруулалтын төслүүд боловсруулж хэрэгжүүлэх талаар хувийн хэвшилтэй түншлэлийн хүрээнд хамтран ажиллах, дэмжклэг үзүүлэх. | Төр, хувийн хэвшил, олон нийтийн үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Хог хаягдлын тогтвортой менежмент, 3R зарчмыг хэрэгжүүлсэн үйлдвэрлэгч болон шинэ хаягалд бага гаргах технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь банк, санхүүгийн байгууллага, орон нутгийн хөгжлийн сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжийг хангахад анхаарах. | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэнэ Үйл ажиллагаагаа өргөжүүлснээр нэмэлт орлого олох боломж нэмэгдэнэ. | - | 1 | 1 | 1 | Хувийн хэвшлийн хөрөнгө | СЗДТГ | ААНБ-ын удирдлага, Иргэдийн бүлэг |
| 5.5. Хог хаягдлыг дахин боловсруулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг ногоон худалдан авалтаар дэмжих. | Хог хаягдлыг дахин боловсруулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг ногоон худалдан авалтаар дэмжкинэ | Төрийн байгууллагын ногоон худалдан авалтын эзлэх хувь /%-иар/ | - | 2 | 4 | 6 | Улсын, орон нутгийн төсөв | АЗДТГ, СЗДТГ | ОНӨГ, БОАЖГ, ГХБХБГ, Агентлаг байгуулла гууд |

| | | | | | | | | | |
|--|---|--|---|--|------------|--|---|--------------|--------------------------|
| | <p>Хог хаягдлын менежмент, дахин боловсруулах үйлдвэрийн салбарт дэвшилтэт шинэ арга, технологи нэвтрүүлэх, хөгжлийг дэмжих судалгааг шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, их дээд сургуулиутай хамтран хийж, дахин боловсруулах хог хаягдлын болон үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах ажлыг хамтран зохион байгуулах. Шинэ технологи, инновацийн үйлдвэр байгуулах.</p> | <p>Дахин боловсруулсан ногоон бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдсэн байна. Байгуулах үйлдвэрийн тоо</p> | - | | 2027 онд 1 | | улсын, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | АЭДТГ, СЗДТГ | БОАЖГ, ААНБ-ын удирдлага |
|--|---|--|---|--|------------|--|---|--------------|--------------------------|

----оо----